



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймаг дахь МСҮТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ДОА-2022/151/НА/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Чойбалсан хот  
2022 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
Тэргүүлэх аудитор: Б.Болортуул  
Утас: 7058-4203, Цахим хаяг: [bolortuulb@audit.gov.mn](mailto:bolortuulb@audit.gov.mn)  
Аудитын менежер: И.Сэмжидмаа  
Утас: 7058-4207, Цахим хаяг: [semjidmaai@audit.gov.mn](mailto:semjidmaai@audit.gov.mn)  
Ахлах аудитор: Д.Нармандах  
Утас: 7058-4207, Цахим хаяг: [narmandakhd@audit.gov.mn](mailto:narmandakhd@audit.gov.mn)  
Аудитор: Ч.Удвалноров  
Утас: 7058-4207, Цахим хаяг: [udvalnorovch@audit.gov.mn](mailto:udvalnorovch@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1. Аудитын санал дүгнэлт .....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
3. Аудитын тайлан .....	10
3.1 Ерөнхий зүйл .....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Материаллаг байдал .....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	12
3.8 Аудитын гол асуудал .....	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
4. Аудитын илрүүлэлт.....	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	14

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
НА	Нотлох аудит
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг  
ЗДТ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2022.02.23 № 120  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г ДОРНОД АЙМАГ ДАХЬ МЭРГЭЖЛИЙН  
СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН  
ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Л.ХИШИГТОГТОХ ТАНАА 7

Г АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ 7

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ

011020890

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>378,357,234.37</b>	<b>361,589,410.12</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	00.00	00.00
<b>311</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	00.00	00.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	3,265,762.00	3,265,762.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	3,265,762.00	3,265,762.00
3351	Байгууллагаас авах авлага	3,265,762.00	3,265,762.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	375,091,472.37	358,323,648.12
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	198,930,113.80	179,232,914.80
35110	Тусгай зориулалттай материал	198,930,113.80	179,232,914.80
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	110,671,358.57	108,310,733.32
35410	Бичиг хэргийн материал	868,000.00	1,103,000.00
35420	Аж ахуйн материал	91,812,581.00	87,517,807.00
35430	Сэлбэг хэрэгсэл	3,801,450.00	105,500.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	921,798.00
35450	Барилгын засварын материал	6,301,827.57	4,949,427.57
35460	Хүнсний материал	7,887,500.00	13,713,200.75
35600	Мал амьтад	65,490,000.00	70,780,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>6,119,944,174.51</b>	<b>6,231,858,474.38</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	6,119,944,174.51	6,231,858,474.38
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	5,814,569,174.51	5,926,483,474.38
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,732,125,860.00	4,732,125,860.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-273,059,083.62	-371,972,328.54
39203	Авто-тээврийн хэрэгсэл	73,516,000.00	105,170,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-66,515,166.16	-51,705,832.72
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,108,589,429.00	1,318,856,302.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-768,338,524.80	-818,282,931.19
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	139,095,615.59	141,563,315.59
39208	Хуримтлагдсан элэгдэл	-118,654,608.50	-121,639,773.76
39214	Бусад үндсэн хөрөнгө	949,818,176.00	949,818,176.00
39217	Ном	37,991,477.00	42,550,687.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	305,375,000.00	305,375,000.00
39301	Програм хангамж	17,955,000.00	17,955,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-17,955,000.00	-17,955,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	305,375,000.00	305,375,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>6,498,301,408.88</b>	<b>6,593,447,884.50</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>4,828,875.00</b>	<b>3,248,875.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	4,828,875.00	3,248,875.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	4,828,875.00	3,248,875.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	4,828,875.00	3,248,875.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	4,828,875.00	3,248,875.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>6,493,472,533.88</b>	<b>6,590,199,009.50</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	6,493,472,533.88	6,590,199,009.50
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	735,645,332.00	735,645,332.00
51101	Өмч: - төрийн	735,645,332.00	735,645,332.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	5,352,620,234.88	5,449,346,710.50
51210	Өмнөх үеийн үр дүн	5,352,620,234.88	5,352,620,234.88
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	96,726,475.62
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	405,206,967.00	405,206,967.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>6,498,301,408.88</b>	<b>6,593,447,884.50</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,545,098,961.00</b>	<b>1,376,830,883.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>486,296,753.00</b>	<b>312,268,083.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	486,296,753.00	312,268,083.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	486,296,753.00	312,268,083.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,614,500.00	8,500,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	478,682,253.00	303,768,083.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,058,802,208.00</b>	<b>1,064,562,800.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,028,073,100.00	1,055,272,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,028,073,100.00	1,055,272,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	30,729,108.00	9,290,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,173,408.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	21,555,700.00	9,290,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,293,809,838.21</b>	<b>1,279,550,157.24</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,293,809,838.21</b>	<b>1,279,550,157.24</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,203,578,793.38	1,157,820,060.56
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>711,351,898.87</b>	<b>714,287,942.00</b>
210101	Үндсэн цалин	710,861,143.87	374,807,879.00
210102	Нэмэгдэл	490,755.00	276,341,802.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	23,899,960.00
210104	Урамшуулал	00.00	38,123,026.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	1,115,275.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>88,251,560.30</b>	<b>92,664,886.32</b>
210201	Тэтгэврийн даатгал	60,184,709.02	64,818,200.61
210202	Тэтгэмжийн даатгал	7,080,554.41	7,131,785.85
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,664,443.54	5,705,428.63
210204	Ажилгүйдлийн даатгал	1,392,895.55	1,364,498.73
210205	Эрүүл мэндийн даатгал	13,928,957.78	13,644,972.50
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>65,512,544.00</b>	<b>60,892,900.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	14,998,931.00	13,487,200.00
210302	Түлш, халаалт	38,590,378.00	37,171,900.00
210303	Цэвэр, бохир ус	11,923,235.00	10,233,800.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>13,445,713.00</b>	<b>21,081,768.00</b>
210401	Бичиг хэрэг	3,605,880.00	3,081,600.00
210402	Тээвэр, шатахуун	4,278,640.00	3,225,192.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,045,653.00	2,746,726.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,153,140.00	1,717,350.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	362,400.00	10,310,900.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>16,930,519.00</b>	<b>13,512,128.25</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	68,960.00	676,200.00
210502	Хоол, хүнс	15,861,559.00	9,083,728.25
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	3,752,200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>13,063,183.00</b>	<b>193,200.00</b>
210604	Урсгал засвар	13,063,183.00	193,200.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>377,700.00</b>	<b>302,200.00</b>
210702	Дотоод албан томилолт	377,700.00	302,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,783,760.00</b>	<b>1,463,250.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,188,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	998,200.00	473,450.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	250,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	597,560.00	739,800.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>291,861,915.21</b>	<b>253,421,785.99</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,880,000.00	10,750,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	57,989,527.00	63,986,353.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	231,992,388.21	178,685,432.99
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>90,231,044.83</b>	<b>121,730,096.68</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>46,132,700.00</b>	<b>108,047,020.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,286,310.00	67,670,020.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	24,754,090.00	39,557,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,092,300.00	820,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>44,098,344.83</b>	<b>13,683,076.68</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	44,098,344.83	13,683,076.68
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>251,289,122.79</b>	<b>97,280,725.76</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>00.00</b>	<b>554,250.14</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	554,250.14
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>00.00</b>	<b>-554,250.14</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>251,289,122.79</b>	<b>96,726,475.62</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	735,645,332.00	405,206,967.00	5,239,676,120.45	6,380,528,419.45
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>735,645,332.00</b>	<b>405,206,967.00</b>	<b>5,239,676,120.45</b>	<b>6,380,528,419.45</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-37,753,262.62	-37,753,262.62
C08	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>735,645,332.00</b>	<b>405,206,967.00</b>	<b>5,352,620,234.88</b>	<b>6,493,472,533.88</b>
D01	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>735,645,332.00</b>	<b>405,206,967.00</b>	<b>5,352,620,234.88</b>	<b>6,493,472,533.88</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>735,645,332.00</b>	<b>405,206,967.00</b>	<b>5,352,620,234.88</b>	<b>6,493,472,533.88</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй	00.00	00.00	00.00	00.00

	олз, гарз				
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	96,726,475.62	96,726,475.62
D09	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>735,645,332.00</b>	<b>405,206,967.00</b>	<b>5,449,346,710.50</b>	<b>6,590,199,009.50</b>

#### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,066,416,708.00</b>	<b>1,073,062,800.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>7,614,500.00</b>	<b>8,500,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	7,614,500.00	8,500,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,614,500.00	8,500,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,614,500.00	8,500,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,058,802,208.00</b>	<b>1,064,562,800.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,028,073,100.00	1,055,272,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,028,073,100.00	1,055,272,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	30,729,108.00	9,290,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,173,408.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	21,555,700.00	9,290,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,063,739,908.00</b>	<b>1,070,036,900.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,063,739,908.00</b>	<b>1,070,036,900.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>973,779,163.17</b>	<b>948,306,803.32</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	708,433,553.58	714,287,942.00
210101	Үндсэн цалин	443,982,708.02	420,724,534.00
210102	Нэмэгдэл	199,661,989.56	230,520,035.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,229,088.00	23,804,612.00
210104	Урамшуулал	37,559,768.00	37,888,761.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	1,350,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>89,526,635.59</b>	<b>92,664,886.32</b>
210201	Тэтгэврийн даатгал	60,989,736.39	64,818,200.61
210202	Тэтгэмжийн даатгал	7,134,199.99	7,131,786.45
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,707,299.91	5,705,428.23
210204	Ажилгүйдлийн даатгал	1,426,899.87	1,364,498.73
210205	Эрүүл мэндийн даатгал	14,268,499.43	13,644,972.30
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>66,224,544.00</b>	<b>60,892,900.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	14,998,931.00	13,487,200.00
210302	Түлш, халаалт	38,590,378.00	37,171,900.00
210303	Цэвэр, бохир ус	12,635,235.00	10,233,800.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>19,433,448.00</b>	<b>23,044,026.00</b>
210401	Бичиг хэрэг	2,100,395.00	3,081,600.00
210402	Тээвэр, шатахуун	4,643,500.00	3,225,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,045,653.00	2,746,726.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,085,400.00	3,679,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,558,500.00	10,310,900.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>21,692,809.00</b>	<b>18,484,829.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,170,200.00	676,200.00
210502	Хоол, хүнс	16,306,309.00	14,056,429.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,216,300.00	3,752,200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>7,308,600.00</b>	<b>193,200.00</b>
210604	Урсгал засвар	7,308,600.00	193,200.00

<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>377,700.00</b>	<b>302,200.00</b>
210702	Дотоод албан томилолт	377,700.00	302,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,214,600.00</b>	<b>1,463,250.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,188,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	998,200.00	473,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	228,700.00	250,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	799,700.00	739,800.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>57,567,273.00</b>	<b>36,973,570.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	6,774,170.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	57,567,273.00	30,199,400.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>89,960,744.83</b>	<b>121,730,096.68</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>45,862,400.00</b>	<b>108,047,020.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,286,310.00	67,670,020.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	24,754,090.00	39,557,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,822,000.00	820,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>44,098,344.83</b>	<b>13,683,076.68</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	44,098,344.83	13,683,076.68
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>2,676,800.00</b>	<b>3,025,900.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>2,676,800.00</b>	<b>3,025,900.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>2,676,800.00</b>	<b>3,025,900.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>2,676,800.00</b>	<b>3,025,900.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,676,800.00	3,025,900.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-2,676,800.00</b>	<b>-3,025,900.00</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,063,772,800.00	1,051,073,303.32
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,063,772,800.00	1,051,073,303.32
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	951,802,200.00	943,026,283.32
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	713,424,700.00	712,937,942.00
210101	Үндсэн цалин	446,864,300.00	420,724,534.00
210102	Нэмэгдэл	197,477,900.00	230,520,035.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	30,888,000.00	23,804,612.00
210104	Урамшуулал	38,194,500.00	37,888,761.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	96,312,200.00	92,482,636.32
210201	Тэтгэврийн даатгал	67,775,300.00	64,635,950.61
210202	Тэтгэмжийн даатгал	7,134,200.00	7,131,786.45
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,707,400.00	5,705,428.23
210204	Ажилгүйдлийн даатгал	1,426,800.00	1,364,498.73
210205	Эрүүл мэндийн даатгал	14,268,500.00	13,644,972.30
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	60,892,900.00	60,892,900.00
210301	Гэрэл, цахилгаан	13,487,200.00	13,487,200.00

210302	Түлш, халаалт	37,171,900.00	37,171,900.00
210303	Цэвэр, бохир ус	10,233,800.00	10,233,800.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>23,777,300.00</b>	<b>23,631,426.00</b>
210401	Бичиг хэрэг	3,081,600.00	3,081,600.00
210402	Тээвэр, шатахуун	3,225,200.00	3,225,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,892,600.00	2,746,726.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,679,600.00	3,679,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,898,300.00	10,898,300.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>22,446,000.00</b>	<b>18,484,829.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	693,800.00	676,200.00
210502	Хоол, хүнс	18,000,000.00	14,056,429.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,752,200.00	3,752,200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>193,200.00</b>	<b>193,200.00</b>
210604	Урсгал засвар	193,200.00	193,200.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>302,200.00</b>	<b>302,200.00</b>
210702	Дотоод албан томилолт	302,200.00	302,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,815,800.00</b>	<b>1,463,250.00</b>
210803	Даатгалын үйлчилгээ	826,000.00	473,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	250,000.00	250,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	739,800.00	739,800.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>32,637,900.00</b>	<b>32,637,900.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	32,637,900.00	32,637,900.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>111,970,600.00</b>	<b>108,047,020.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>111,970,600.00</b>	<b>108,047,020.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	71,593,600.00	67,670,020.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	39,557,000.00	39,557,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	820,000.00	820,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,063,772,800.00</b>	<b>1,051,073,303.32</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,055,272,800.00</b>	<b>1,042,573,303.32</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,055,272,800.00	1,042,573,303.32
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>8,500,000.00</b>	<b>8,500,000.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,500,000.00	8,500,000.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	-	-
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	-	-
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	50.00	50.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	36.00	36.00
620003	Үйлчлэх ажилтан	13.00	13.00

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>8,306,420.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>8,306,420.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	8,306,420.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,350,000.00

210105	Гэрээт ажлын хөлс	1,350,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	182,250.00
210201	Тэтгэврийн даатгал	182,250.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	6,774,170.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,774,170.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	8,306,420.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	8,306,420.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дорнод аймаг дахь МСҮТ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд хууль тогтоомж холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нармандах, аудитор Ч.Удвалноров нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер И.Сэмжидмаа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нар тус тус хэрэгжүүлсэн.

Дорнод аймаг дахь МСҮТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Олон улсын нийтлэг жишиг, хандлагад нийцүүлэн мэргэжлийн ур чадвар, боловсрол эзэмшүүлэх, хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөхүйц хөрвөх чадвартай, ажлын байртай, мэргэжилтэй ажилтан бэлтгэн гаргах, мэргэшлийг дээшлүүлэх, хөдөлмөрийн болон харилцааны соёл төлөвшүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дорнод аймаг дахь МСҮТ нь хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын нэгжгүй. Харин дотоод чанарын баталгаажуулалт хариуцсан ахлах ажилтантай. Энэхүү ажилтан нь байгууллагын үйл ажиллагаанд хагас, бүтэн жилээр дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дорнод аймаг дахь МСҮТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 1,290.8 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 12.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 9.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Авлага дансны үлдэгдэл 3.2 сая төгрөгийн байгууллагаас авах авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 358.3 сая төгрөг болж 16.8 сая төгрөгөөр буурсан нь тусгай зориулалттай материал буурсантай холбоотой байна. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 7,613.4 сая төгрөг болж 248.9 сая төгрөгөөр өссөн нь машин тоног төхөөрөмжийн өсөлтөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данс нь төсвийн хөрөнгийн худалдан авалтаар 2.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 0.5 сая төгрөгийн тавилга хэрэгсэл, үнэ төлбөргүй шилжиж ирсэн 50.9 сая төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, 223.7 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 9.0 сая төгрөгийн тавилга хэрэгсэл, 4.5 сая төгрөгийн номын фондоор нэмэгдсэн байна. Үндсэн хөрөнгө акталсан 42.2 сая төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 3.2 сая төгрөгийн хувь хүмүүст төлөх өглөгтэй байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 168.3 сая төгрөгөөр буурсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлоготой холбоотой байна. Нийт зардал өмнөх оноос 14.3 сая төгрөгөөр буурсан нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, нормативт зардал, бараа үйлчилгээний бусад зардал зэргээс шалтгаалсан байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,063.8 сая төгрөгөөр, нийт зарлагыг 1,063.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,063.8 сая төгрөгийн төсөв баталснаас 1,055.3 сая төгрөгийг улсын төсвөөс, 8.5 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 98.8 хувь буюу 1,051.1 сая төгрөг, буцаан төвлөрүүлсэн 1.8 хувь буюу 12.7 сая төгрөг байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилтийн дансанд үндсэн үйл ажиллагааны орлого 9.3 сая төгрөгийг төвлөрүүлж урсгал үйл ажиллагааны зардалд нийт 8.3 сая төгрөгийг зарцуулж, 1.0 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ, үйл явдал гараагүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дорнод аймаг дахь МСҮТ нь 2021 онд нийт 130 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас хуулийн хугацаанд 115 мэдээллийг бүрэн мэдээлж, 15 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

Батлагдсан төсвийн зардлын дүнд 10 хувийн хэмнэлттэй байхаар удирдан зохион байгуулж ажиллаагүйд албан шаардлага хүргүүлсэн.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар итгэл үзүүлсэн байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар авлага, өглөгийг үзэх.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 15.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2.2 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 13.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1 алдаа зөрчилд зөвлөмж өгсөн.

Тус байгууллагын он дамжсан авлага нь 2015 онд шийдвэрлэгдсэн Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн шүүхийн 102ШШ2015/04741 тоот захирамжтай. Нийт 14.5 сая төгрөгийн авлагаас өмнөх жилүүдэд барагдуулсаар, 3.3 сая төгрөгийн авлагатай үлдсэн байна. 2020-2021 онд цар тахлаас болж төлөх боломжгүй байгаа тухай хариу мэдэгдсэн байна.

### **4.1 Залруулсан алдаа**

Тайлант хугацаанд залруулсан алдаа байхгүй болно.

### **4.2 Төлбөрийн акт**

Түрээсийн орлого 5.5 сая төгрөгөөс төсөвт төвлөрүүлэх 40 хувь буюу 2.2 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь "Төрийн өмчийн түрээсийн төлбөрийг улсын төсөвт оруулна" гэж заасныг зөрчсөн байна.

### **4.3 Албан шаардлага**

1. Тайлант оны эцэст 4.5 сая төгрөгийн хоол хүнсний материалыг худалдан авч нөөцөлсөн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:", 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 43 дугаар зүйлийн 43.5-д "Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй." гэж заасныг зөрчсөн, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Он дамжсан 3.3 сая төгрөгийн авлага, 3.2 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой

удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3. Жолоочийн замын хуудсыг тус байгууллагад хамааралгүй этгээдээр бөглүүлж 0.1 сая төгрөгийг зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.”, 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

#### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. *Шилэн данстай холбоотой асуудал*

1.1. *Илрүүлэлт:* Тайлант онд Шилэн дансны сайтад 15 мэдээлэл хуулийн хугацаа хоцроон мэдээлсэн.

1.2. *Өгсөн зөвлөмж:* Шилэн дансны тухай хуулийн 6.1-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” гэсэн заасны дагуу мэдээллийг хуулийн хугацаанд байршуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 5 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Дорнод аймаг дахь МСҮТ	6	15.9	-	-	1	2.2	4	13.7	1	-

/сая төгрөгөөр/